БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ

**СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОР БАРИЛГА ХУДАЛДАН АВАХ /СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 29 ДҮГЭЭР ХОРОО/ АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 03-р сарын 17-ны өдөр № 2020/23. Улаанбаатар хот

| № | Үндэслэл | Шаардлага |
|---|---|---|
| 1 | Барилга байгууламжийн байршил | - Улаанбаатар хот. Сонгинохайрхан дүүрэг 29 дүгээр хороо |
| 2 | Зориулалт, хүчин чадал | - Сургууль, цэцэрлэгийн цогцолбор |
| 3 | Барилгын үндсэн бүтээц, материал | - Төмөр бетон каркас |
| 4 | Барилгын суурь | - Төмөр бетон суурьтай байх |
| 5 | Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр | - Дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх, эсвэл өөрийн эх үүсвэртэй байх.<br>- Цахилгааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх /Нөөц эх үүсвэр суурилуулсан байх, /Дизель генератор/<br>- Цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх, эсвэл өөрийн эх үүсвэртэй байх.<br>- Гадна холбооны оролттой байх /шилэн кабель болон физик кабель/ |
| 6 | Галын аюулгүй байдлын нөхцөл | - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21.02.02/;<br>- Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/<br>- Утаа мэдрэгч, галын дохиололтой байх |
| 7 | Өрөө танхим | Сургууль, цэцэрлэгийн анги танхимууд нь норм, стандарт заагдсан өрөө тасалгаа иж бүрэн байх.<br>Барилга, байгууламжид зайлшгүй байвал зохих өрөө тасалгаа:<br>- Узель, цахилгааны өрөө, сервирийн өрөө,<br>- Цэцэрлэг:<br>Бүлгийн өрөө, хүлээн авах өрөө, хувцас солих өрөө, ор хөнжил хураах өрөө, ариун цэврийн өрөө, дуу хөгжим, гимнастикийн хичээлийн танхим, гонх, коридор, шатны хонгил, захиргааны өрөө, эмчийн өрөө, тусгаарлах өрөө, багш ажилчдын өрөө, угаалга, индүүдлэг, хатаалгын өрөө, чийрэгжүүлэлтийн танхим, гал тогоо, агуулах<br>- Сургууль:<br>Ангийн өрөөнүүд, хүлээн авах өрөө, ариун цэврийн өрөө, хөгжмийн анги, гонх, коридор, шатны хонгил, захиралын өрөө, захиргааны өрөө, эмчийн өрөө, тусгаарлах өрөө, багш ажилчдын өрөө, урлаг заал, спорт заал болон түүний дагалдах өрөө, гал тогоо, агуулах, хооллох заал, лаборатори анги танхим /хими, физик/, математик, гадаад хэл, монгол хэл, дүрслэх урлаг, шугам зураг, мэдээлэл зүй, хөдөлмөр эр, эм кабинет гэх мэт |

| | | |
|---|---|---|
| 8 | Онцгой нөхцөл | Барилга байгууламж:<br>- Сургууль, цэцэрлэг нь тусдаа бие даасан барилга байгууламжтай байх.<br>- Багш ажилчдын аруин цэврийн өрөө шүршүүртэй байх, мөн ажилчдын амралтын өрөөтэй байх.<br>- Сурагчдийн сурах, амрах, тоглох орчинг бүрдүүлсэн байх<br>- Бүлгийн өрөөнүүдэд нарны гэрэл шууд тусахаар төлөвлөх, цонхны шил нь дулаан алдагдал бага, норм стандарт хангасан байх<br>- Бүлгийг хүүхдийн насаар нь ангилж, тус бүрд нь хүлээн авахтай байхаар, 2-оос доошгүй гарцтай байх.<br>- Нэг ангид 20-25 хүүхэд байхаар бүлгийг тооцон төлөвлөсөн байх<br>- Сурагчдийн сурах, амрах, тоглох орчинтой байх.<br>- Бага ангийн хүүхдийн бүлгийн өрөөг 1 дүгээр давхарт байх<br>- Цэцэрлэгийн хувьд дуу хөгжмийн анги болон урлаг заалыг хамт төлөвлөсөн байж болно.<br>- Бүлэг тус бүрийн аяга таваг угаах 3 дамжлагатай тосгуурыг төлөвлөсөн байх<br>- Шугам сүлжээний тоолуур сургууль, цэцэрлэг тус тусад нь төлөвлөсөн байх<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандусыг норм дүрмийн дагуу төлөвлөсөн байх<br>- Барилгад хэрэглэсэн материалууд нь чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх<br>- Сургуулийн нэгдүгээр ддавхарт хөгжлий нбэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө, орц гарц болон бусад тоноглолуудыг горм стандартын дагуу хийж гүйцэтгэсэн байх<br>- Ариун цэврийн өрөөнүүд эр, эм тус тусдаа мөн насны онцолгоос хамаарч тус тусад нь төлөвлөх,<br>- Цэцэрлэгийн барилгын бүлгийн ариун цэврийн өрөөнүүдэд угаагуур, суултуур, шүршүүр, алчуур оо сойз тавих тавиур, багшид зориулсан угаагуур, мөн суултуур хоорондын дунд стандарт хангасан тасалгаа байна.<br>- Сургууль, цэцэрлэгийн аваарын гарц, аваарын шат зэрэг нь аюулгүй ажиллагааг бүрэн хангасан ба норм дүрэм дагуу хийж гүйцэтгэсэн байх<br>- Барилгуудын гол ба туслах орц гарц, саравч довжоо зэргийг норм дүрмийн дагуу хийгдсэн байх<br>Гадна талбай:<br>- Гаднах явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдсан байх;<br>- Сургууль, цэцэрлэгийн эдэлбэр газраар гадга хашаа норм стандартын дагуу хашаа төлөвлөсөн байх.<br>- Норм дүрэм, стандарт хангасан спорт талбайтай байх. /Спорт талбайн тоноглол бүрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байх, бага насны хүүхэд бэртэж гэмтэхээс хамгаалсан байх.<br>- Гадна тохижилтын хувьд сургууль, цэцэрлэг тусдаа насны онцлогт тохиорсон тоглоомын талбай, сүүдрэвч, хогийн сав, гэрэлтүүлэг, гамшгийн үед цуглах талбай, ногоон байгууламж авто зогсоол, явган зам талбай зэргийг норм стандарт хангасан байх<br>- Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг |

| | | |
|---|---|---|
| | | тэмдэглэгээг стандартын дагуу хийсэн байх.<br>- Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг саадгүй түргэн аврагдах нөхцөлийг бүрдүүлсэн байх;<br>- Барилгын орц гарцыг гадна авто замтай болон явган замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх<br>Инженерийн шугам сүлжээ:<br>- Нөөц цахилгааны эх үүсвэртэй байх./ /Дизель генератор/<br>- Ангиудын агааржуулалт, салхивчийн нэгдсэн системийг норм нормативын дагуу төлөвлөсөн байх.<br>- Халаах хэрэгсэл болон хаалт арматурыг бага насны хүүхдүүдийн аюулгүй байдал хангахаар хамгаалалттай хаалттай байх.<br>- Насны ангилалд тохирсон ариун цэврийн тоноглол төлөвлөсөн байх<br>- Цэвэрлэгээ үйлчилгээнд зориулсан тосгуууртай байх.<br>- Цэвэр усны гадна худагт галын гидрант төлөвлөсөн байх<br>- Бүлгийн өрөө тус бүрд хаалганы дээр цэнэг хураагуууртай ослын гэрэлтүүлэгтэй байх<br>- Ослын гэрэлтүүлгийг орц гарц, коридорт норм стандартын дагуу байрлуулсан байх<br>- Тус барилгад розетка /ХТ/ төлөвлөхдөө норм стандартыг мөрдөж байршуулсан байх.<br>- Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангасан байх<br>- Бүлгийн өрөө тус бүрд камер төлөвлөсөн байх /NVR/<br>- Гадна хяналтын камер төлөвлөх, Аудио систем төлөвлөсөн байх<br>- Үүдний хэсэгт /24 цагаар хүн суух боломжтой/ холбоо дохиоллын удирдлагын төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулж хяналт хийх боломжтой байх<br>- Эрхлэгчийн өрөөнд хяналтын дэлгэц байх<br>- Гадна худагт галын гидрант төлөвлөсөн байх |
| 9 | Төслийн иж бүрдэл | Баримт бичгийн иж бүрдэл:<br>- Газрын гэрчилгээ, кадастрын зураг<br>- Инженер геологийн дүгнэлт<br>- Байр зүйн дэвсгэр зураг<br>- Онцгой байдлын дүгнэлт<br>- Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт /Эрүүл ахуй/<br>- Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/<br>- Техникийн нөхцөлүүд /УСУГ, УБДС, УБЦТС, МХС/<br>- Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулсан комиссын акт<br>- Барилгын хувийн хэрэг болон бусад холбогдох бичиг баримт<br>- Барилгын тухай хуулийн 14.3, 14.6-д заасны дагуу чанарын баталгаа гаргасан албан тоот<br>Зургийн төслийн иж бүрдэл:<br>1. Эскиз /батлагдсан/<br>2. Ажлын зураг /батлагдсан/<br>- ЕТ- Ерөнхий төлөвлөгөө<br>- БА- Барилга архитектур<br>- ТХ-Технологийн зураглал<br>- ББ- Барилга бүтээц / Бүтээцийн тооцооны хамт/ |

| | | |
|---|---|---|
| | | - ХАС- Халаалт агаар салхивч<br>- ЦБУ- Цэвэр бохир ус<br>- ДГ- Дотор гэрэлтүүлэг<br>- ХТ- Хүчит төхөөрөмж<br>- ХД- Холбоо дохиолол<br>- ГД- Гадна дулаан хангамж<br>- УХАТ- Ус хангамж ариутгах татуурга<br>- ГЦ- Гадна цахилгаан хангамж<br>- ГХ- Гадна холбоо дохиолол |
| 10 | Архитектур орон зайн төлөвлөлтөнд тавигдах шаардлага | <u>Ерөнхий төлөвлөгөө:</u><br>- Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай байх<br>- Цэцэрлэгийн гадаа жагсаалын талбайтай байх<br>- Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөсөн байх.<br>- Гадаа ил бага хэмжээний спорт талбай, амралтын талбай, хүүхдүүдийн тоглоомын талбай байх.<br>- Анги хоорондох хонгил буюу коридорт хичээлийн хэрэглэл хийх шүүгээ тавихад сурагчдад зорчих зай талбай хангалттай байх<br>- Спорт заал нь сургуулийн хүчин чадлаас хамаач норм дүрэм, стандарт хангасан байх.<br>- Гал тогоо болон түүний дагалдах өрөө тасалгааг норм дүрмийн дагуу төлөвлөсөн байх. |
| 11 | Дараах БНбД хангасан байх | <u>Хууль тогтоомжууд:</u><br>- Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Боловсролын тухай хууль<br><u>Норм, нормативууд:</u><br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/;<br>- Олон нийт иргэний барилгын норм дүрэм /БНбД 31.03.03/;<br>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/;<br>- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;<br>- Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт /БНбД 31-113-11/<br>- Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж /БНбД II-66-88<br>- Дотор сантехникийн ажил /БНбД 3.05.01-88/<br>- Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНбД 41-01-11/<br>- Дулаан хангамж /БНбД 41-02-13/<br>- Дулааны шугам сүлжээ /БНбД 3.05.03-95/<br>- Цахилгаан техникийн ажил /БНбД 3.05.07-90/<br>- Автоматжуулалтын систем /БНбД3.05.07-90/<br>- Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12<br>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21.02.02/;<br>- Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/<br>- Ариутгах татуурга, Гадна сүлжээ ба байгууламж /БНбД 40-01-14/<br>- Усан хангамж, бохир ус, гадна сүлжээ ба байгууламж /БНбД |

| | | |
|---|---|---|
| | | 40-02-06/<br>- Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга /БНбД 40-05-98/05*/<br>Стандартууд:<br>- “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2000<br>- Барилгын цонх Техникийн ерөнхий шаардлага MNS 5802:2007<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/:<br>- Бусад холбогдох стандартууд |
| 12 | Төлбөр тооцоо | - Нийлүүлэгч тал цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, холбоо мэдээлэл, газар, татварын гэх мэт өр төлбөргүй байна. |
| 13 | Санхүүжилт | - Улсын төсвийн хөрөнгөөр гэрээг үндэслэн санхүүжинэ |

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН СХОТХ-ИЙН ДАРГА ........................ / Ж.ЭНХТӨР/

НИЙСЛЛЭИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗТХ-ИЙН ДАРГА ........................./Б.ЛХАГВАЖАВ/

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЛЭИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЖР ................................/З.НЭРМӨНХ/

НИЙСЛЛЭИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЖР ................................/Э.БАТЦЭНГЭЛ/

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ЕБС-ИЙН БАРИЛГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН ......................../Э.БАЯРМАГНАЙ/

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
СӨББ-ЫН БАРИЛГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЭРГЭЖИЛТЭН ........................./Д.ИРМҮҮНЗАЯА/